

ӨНӨӨГИЙН ХЯТАДЫН НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ТОЙМ

Түмэнцэцэг*

Сэлэнгэ**

Нэг. Нийгмийн хөгжлийн ашигтай орчин

Хятад бол 1,2 тэрбум хүн амтай хөгжиж буй орон юм. Шинэтгэл, нээлттэй бодлого явуулсаны үр дүнд ард түмний амьдрал улам бүр дээшилж байна. Хятадын Засгийн газар 1996 оны 3-р сард “БНХАУ-ын улс ардын аж ахуй, нийгмийн хөгжлийн IX 5 жилийн төлөвлөгөө ба 2010 он хүртэлх хэтийн зорилтот хөтөлбөр”, мөн 2001 оны 3-р сард “БНХАУ-ын улс ардын аж ахуй, нийгмийн хөгжлийн X 5 жилийн төлөвлөгөө”-г батлав. Энэ хоёр “хөтөлбөр” нь Хятадын эдийн засаг, нийгмийн хөгжлийг ахиулах, нийгмийн бүхий л бодлогыг зохицуулах нийгмийн өргөн давхаргыг татан оролцуулахыг чухалчилан заасан юм. Нийгмийг хөгжүүлэх улсын макро бодлогын зөв удирдлагын дор, ядууг тэтгэх уламжлалт бодлогоос шинэ цаг үеийн нийгмийн ядууг тэтгэх өөрчлөлтийн түүхэн хувьсал, ялангуяа өнгөрсөн 20 жилийн шинэтгэл, нээлттэй бодлого, хөгжил, өнөөгийн Хятадын эдийн засгийн нүсэр байдал, төрийн бодлогоор дамжин ард түмнийг амгалан байлгах, дэлхийн олон орны хамтын ажиллагааны хүрээг цаашид өргөжүүлэх нь нийгмийг бүх талаар хөгжүүлэх ашигтай орчинг бий болгохын төлөө юм.

Хоёр. Нийгмийг хөгжүүлэх үндсэн нөхцөл

IX 5 жилийн төлөвлөгөөний үед Хятадын улс ардын аж ахуй түргэн, хурдацтай, эрүүл саруулаар хөгжиж улс орны нийт хүчин чадал нилээд сайжирлаа. Дотоодын үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүн 2000 онд 8940,4 тэрбум юаньд хүрч жилийн дундаж өсөлт 8,3% байв. Ард түмний амьдрал идэж уух, өмсөж зүүх байдлаас гарч, чинээлэгжин дээшлэж байна. Хятадын хөдөө тосгоны эдийн засаг тогтвортой өсч, улсын үйлдвэр аж ахуйн газрын өөрчлөлт улам бүр гүнзгийрч, зах зээлийн эдийн засгийн механизм аажмаар эрүүлжиж байна. Баруун бүсийн нээлттэй бодлого нь Хятадын шинэчлэл, бүтээн байгуулалтын гурав дахь чухал хэсэг болж байна. Өндөр хурдацтай, мэдээллийн

*Түмэнцэцэг – БНХАУ. Өвөр Монголын их сургуулийн Хөрш зэргэлдээ орон судлалын хүрээлэнгийн захирал, дэд профессор

**Сэлэнгэ – БНХАУ. Өвөр Монголын Нийгмийн ШУА-ийн Түүхийн хүрээлэн

өргөн сүлжээ, төвлөрсөн цахилгаан хангамж, шинэ төрлийн зөөгч пуужин зэрэг дээд зэргийн технологи бий болгох, дээд зэрэглэлийн шинэ технологийн үйлдвэрлэлийн төвлөрлийн давуу тал ба хэсэг тус бүрийн зонхилох байдлыг бий болгох томоохон аж ахуйн барилга байгууламжийн төсөл амжилттай урагшилж байна. Эдийн засаг хөгжихийн зэрэгцээ Хятадын Засгийн газар улсын сангаас зарцуулах нийт хөрөнгийн 26%-ийг нийгмийн үндсэн үйлчилгээнд зарцуулах, нийгмийн бүх талын хөгжлийн баттай үндэс суурийг тавихын тулд боловсролын “211”, шинжлэх ухаан, техникийн “863” төсөл, “Цунцун тун” (Тосгон бүрт) радио, телевиз, “8 7” ядууг тэтгэх зэрэг томоохон ажлуудыг хэрэгжүүлж байна.

Гурав. Ядуурлыг арилгах олон жилийн хөдөлмөр

Хятадын Засгийн газар ядуурлыг арилгах стратеги боловсруулж, 1994 оны 3-р сард “8 7 ядууг тэтгэх улсын хэмжээний төлөвлөгөө” –г гаргаж, хүн хүч, эд материал, хөрөнгө санхүүгийн хүчийг төвлөрүүлж, нийгмийн бүх хүчийг дайчлан, 7 жилийн дотор улсын хэмжээнд байгаа 80 сая ядуусын идэх хоол өмсөх хувцасны асуудлыг шийдвэрлэхээр болов. Туйлын ядуурлыг арилгах, харьцангуй ядуурлыг багасгахын тулд Хятадын засгийн газар идэвхитэйгээр ядууг тэтгэх бодлого явуулж байна. Тухайлбал, ядууг тэтгэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, ядууст олгох зээлийн хугацааг сунгах; Дотоодын банкууд тодорхой хугацаанд ядуусыг тэтгэхээр зээл олгож, ашигтай, эргүүлж төлөх боломжтой зээл олгохыг идэвхитэй дэмжих; Оршин суух, хөгжих нөхцөлөөр бага нутагт ард иргэдийг нүүлгэн шилжүүлэх нээлттэй бодлого явуулах; Хөдөө тосгод, алслагдсан ядуу бүсэд мэдээлэл хүргэх асуудлыг дэмжих, “Тосгон бүрт” радио, телевизийн нэвтрүүлэг хүргэх, “Улсын ядууг тэтгэх сургалт”-ийг хэрэгжүүлэх; Ядуу бүс нутгийн сургалтын нөхцөлийг сайжруулах, төв, баруун бүс нутаг болон цөөн тоот үндэстэн суурьшиж байгаа ядуу бүс нутгийг улсаас эн тэргүүнд дэмжих бүсийн тоонд оруулах зэрэг юм. Хятад улс ядуурлыг арилгах ажлаа хурдасгаж, өөрийн улсын нутаг дэвсгэрийн талаас илүү, хүн амын 20-иос дээш хувь, ядуу хүн амын суурьшилт 60-аас дээш хувьтай байгаа баруун бүсийн нутгийг хөгжүүлэх стратегийн бодлогыг хэрэгжүүлж байгаа нь Хятадын ядуурлыг арилгах ажилд томоохон түлхэц болж өгсөн. Ядуу газар нутагт үндсэн бүтээн байгуулалтын ажлыг улсаас дэмжиж, ядуу хүн амын ундны цэвэр ус, ядуу бүс нутгийн зам харилцаа, ядуу айл өрхийн цахилгааны асуудал

гэх мэт бэрхшээлүүдийг үндсэнд нь шийдвэрлэх; Ядуусыг дэмжих сургалтын ажлын төлөвлөгөөг үндэслэн, шинээр 2200 бага сургууль байгуулж, ойролцоогоор 660 мянган оюутан сургаж, Хятадын бичиг үсэггүй залуучуудын тоог 5-аас доош хувь болгож, 2000 он гэхэд ядуу хүн амын тоо 24 сая болтлоо буурсан байна.

Дөрөв. Ажлын байрыг өргөтгөх

Хятадад тулгараад байгаа томоохон асуудлын нэг нь ажлын байрны асуудал юм. 90-ээд оноос хойш жилд дунджаар 10 сая хүн хөдөлмөрийн насанд шилжиж байна. Засгийн газар ажлын байр нэмэгдүүлэх олон арга хэмжээ авч, улмаар, давуу тал харьцангуй ихтэй төвлөрсөн үйлдвэр, аж ахуйн газар, ажлын байрны багтаамж ихтэй үйлчилгээний салбар, хамтын болон хувийн аж ахуйн нэгжийг хөгжүүлэх, нийгмийн үйлчилгээг өргөтгөх, үйлдвэрлэл, өөр өөртөө ажил эрхлэх явдлыг дэмжих зэрэг харилцан холбоотой нийгмийн хөгжлийн бодлого явуулж, зах зээл руу чиглэсэн ажлын байрны механизмыг идэвхитэй бий болгож, эдийн засгийн бүтцийн дагалдах чанарын зохицуулалт, эдийн засгийн мөчлөгийн хүчин зүйлийн нөлөөнөөс Хятадад цомхтголд орсон хүний тоо харьцангуй нэмэгдсэн. Дахин ажлын байр олгох асуудлыг шийдвэрлэхийн тулд засгийн газраас санаачилан дахин их хэмжээний ажлын байрны биржийг нээв. Ажилчдын амьжиргааны баталгаа, дахин ажил эрхлэх сургалтанд оруулсан хөрөнгө эрс өслөө. Гуравдагч үйлдвэрлэлийн (үйлчилгээний салбар) хөгжлийг анхаарч, хотын ажлын байрны хүрээг нэмэгдүүлэх, хот, тосгодын аж ахуйн нэгжийг хөгжүүлэх, газар тариалангийн илүүдэл хүчийг тариалангийн бус үйлдвэрлэл рүү чиглүүлэх, газар тариалангийн үндсэн ажлыг нэмэгдүүлэх, тариалангийн талбайн усжуулалтын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тухайн газрынхаа хөдөө тосгодын ажлын хүчний ажил эрхлэлтийг зохицуулах асуудлыг улам бүр сайжруулах хэрэгтэй.

Тав. Олон нийтэд хандсан нийгмийн үйлчилгээ

- Хятадын Засгийн газар төлөвлөгөөт төрөлтийн бодлогыг идэвхитэйгээр дэлгэрүүлж, хүн амын цэвэр өсөлтийг 9% дотор барьж, хүний хүчин зүйлийг тасралтгүй сайжруулан, улмаар төлөвлөгөөт төрөлтийг хэрэгжүүлж, эмэгтйчүүдийн хуль ёсны эрх ашгийг хамгаалж, эмэгтэйчүүдийн үржил, эрүүл мэндийн харилцан уялдааг сайжруулах.

- Хятадын Засгийн газар их хэмжээний хөрөнгийг хөдөө тосгодын ариун цэврийн үйлчилгээний үндсэн зохион байгуулалтыг бүтээн байгуулахад оруулжээ. Бүс нутгийн эрүүл мэндийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэнээр хотын иргэдэд илүү үр дүнтэй эмчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлж байна. Улс даяар эрүүл мэндийн үйлчилгээний харьцангуй сайжирсан тогтолцоог бий болгож, ард иргэдийн эрүүл мэндийн түвшинг улам дээшлүүлж байна.

- Хятадын засгийн газар “Боловсролын хууль”, “Багш нарын хууль”, “Албан журмын боловсролын хууль”-ийг хэрэгжүүлж, боловсролын зардлыг нэмэгдүүлэх, боловсролын салбарт оруулах хөрөнгө оруулалтын сувгийг өргөтгөх, сургалтын орчинг сайжруулах, сургуульд элсэн орох оюутны тоог нэмэгдүүлж байна. XX зууны сүүлээр Хятадын бага сургуулийн насны хүүхдийн сургуульд элсэн орох хэмжээ 98%-тай байгаа нь үндсэн боловсролын хөгжил нь улсын иргэдийн сурах эрхийг баталгаажуулан, дунд сургуулиудын оюутан элсүүлэлт өргөжиж, дээд сургуулиуд “211 төсөл”-ийг хэрэгжүүлж, их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн барилга ихээр баригдаж, боловсон хүчин бэлтгэх явц хурдасч байна.

- Хятадын засгийн газар нийгмийн даатгалын өөрчлөлт, хөгжлийг хурдасгаж, хотын иргэдийн амьжиргааны доод түвшинг тогтоосон. 1999 оны сүүлээр бүх улсын хэмжээнд 667 хот, 1628 сянь (хошуу), хотын оршин суугчдын амьжиргааны баталгаат доод түвшинг тогтоожээ.

- Хятадын засгийн газар хөгжлийг тууштай дэмжиж, нөөц баялаг, экологийн орчныг хамгаалж, байгаль хамгаалах бүс олноор байгуулснаар барахгүй, устаж үгүй болж буй ан амьтдыг хамгаалахаар хөрөнгө оруулах, хүмүүсийг зохион байгуулах зэрэг тохиромжтой, бодлогын чанартай арга хэмжээ авч явуулж байна.

- Хятадын засгийн газар үндэстэний соёлын өв, түүх, соёлын дурсгалт газруудыг хамгаалах, эдийн засгийн хөгжлийн явцад олдсон бүхий л түүх дурсгалын зүйлсийг хамгаалахад анхаарлаа хандуулж байна.

- Хятадын засгийн газар мэдээ мэдээлэл, радио, телевиз, телефон утас зэрэг төрөл бүрийн нэвтрүүлэх хэрэгслийн хөгжилд 90-ээд оноос хойш ихээхэн анхаарлаа хандуулж байна. Мэдээллийн эх сурвалж хөгжиж, бүх талаар ахин, сонин, сэтгүүлийн төрөл, тоо хэмжээ нэмэгдэж байна. Газар зүй, орон зайн мэдээллийн тогтолцоо аажмаар сайжирч, мэдээллийн тоног, төхөөрөмж, системчилсэн чадавхи илт

нэмэгдлээ. Мэдээллийн техник асар хурдацтайгаар хөгжиж, интернетийн хөгжил ард иргэдийг мэдээ мэдээллийг илүү өргөнөөр хүлээн авдаг болгоод байна.

- Хятадын засгийн газар олон нийтэд зориулсан музей, үзмэрийн газар, номын сан, соёлын ордон, биеийн тамирын ордон зэргийг байгуулахад хөрөнгө зарцуулж байгаа нь ард иргэдийн соёлын түвшин, бие бялдрын хөгжлийг өргөжүүлж байна.

Зургаа. Хөгжлийн бодлогын үр дүн

- Хятадын засгийн газар эмэгтэйчүүдийн байр суурь, хөгжлийг өндөр хэмжээнд анхааран үзэж, 1995 онд улс байгуулагдсанаас хойшхи анхны “Хятадын эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөр (1995-2000)”-ийг гаргасан. Хятадын эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн адил сонгох, сонгогдох тэгш эрхтэй, өөрсдийн гэсэн бүх улсын болон бүс нутгийн шинжтэй байгууллагатай, түүгээр ч барахгүй төрийн хэрэгт идэвхитэй оролцож байгаа нь эмэгтэйчүүд нийгмийн хөгжилд өөрсдийнхөө хүчийг сорьж байгааг илэрхийлж байна.

- Хятадын засгийн газар “Хятадын хүүхдийн хөгжлийн хөтөлбөр”-г боловсруулан хэрэгжүүлж, хүүхдийн оршин амьдрах, хамгаалал болон хөгжилд ерөнхийдөө нааштай ахиц гарч байна. “Өсвөр үеийнхний эрх ашгийг хамгаалах хууль” хятадад дэмжлэг авч, хот хөдөөгийн хүүхдүүд эрүүл саруул өсөн торниж байна.

- Хятадын засгийн газар залуучуудын хөгжлийг анхаарч, тэднийг өсөж боловсроход нь зориулж нийгмийн тааламжтай орчинг бий болгож байна. Хятадын залуус нийгмийн амьдралд идэвхитэйгээр оролцож, залуучуудын сайн дурын үйл ажиллагаанд өргөнөөр оролцож, мансууруулах бодис хэрэглэхээс татгалзах, ядуу зудуу хүмүүст туслах, байгаль орчныг хамгаалах гэх мэтийн нийгмийн олон нийтийн үйл ажиллагаанд улам бүр чухал байр суурьтай болсоор байна.

- Хятад улсын хүн амд өндөр настны эзлэх хэмжээ хурдацтайгаар өсөж байна. 2000 он гэхэд 60-аас дээш настан хүн амын 10%-ийг эзлэхээр болж байна. Хятадын “Өндөр настны эрх ашгийг хамгаалах хууль” болон “Хятадын өндөр настны ажил эрхлэлтийн хөгжлийн хөтөлбөр” үр дүнтэйгээр хэрэгжиж байна. Хятад улс одоо ХХI зууны эхний хагаст өндөр настны талаархи улсын бодлогыг чухалчилан боловсруулж байна.

- Хятад улс “Тахир дутуу хүмүүсийн дэлхийн дахины үйл ажиллагааны удирдамж” болон “Тахир дутуу хүний боломж , тэгш

эрхийн зарчим”-ийг хэрэгжүүлж, тахир дутуу хүмүүсийн амьдралын түвшинг сайжруулах, тахир дутуу хүмүүсийн тэгш эрхтэй оролцоог улам нэмэгдүүлж байна. 60 сая гаруй тахир дутуу хятад хүмүүсийн тэгш эрхийн асуудал Хятад улсын засгийн газрын анхаарлын төвд байна. Одоогийн байдлаар Хятадын тахир дутуу хүмүүсийн ажил эрхлэлт 70-аас илүү хувьтай байна. Тахир дутуу хүмүүсийг дэмжих дүрэм журмыг 90-ээд оны сүүл үеэс улсын барилга байгууламжийн хяналтанд хамруулсан. Хятад улс засгийн газраар удирдуулсан тахир дутуу иргэдийг эрүүл болгох тогтолцоог хэрэгжүүлсэн. Тахир дутуу хүүхдийн тусгай сургалт ихээхэн хөгжиж, тахир дутуу хүүхдүүд сургуульд хамрагдах хэмжээ 70%-тай байна.

- Хятад улс 56 үндэстэнтэй. Хятад улсын Үндсэн хуульд зааснаар үндэстэн бүр бүгд тэгш эрх эдэлнэ. Цөөн тоот үндэстэний бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих, цөөн тоот үндэстэний амьдралын түвшинг сайжруулах нь Хятад улсын засгийн газрын анхаарсаар ирсэн гол асуудал билээ. Цөөн тоот үндэстэний төлөөлөл улсын болон бүс нутгийн бодлого боловсруулалтад оролцож, улс эх орон, үндэстэнийхээ эрх ашгийг хамгаалж байна. Цөөн тоот үндэстний төвлөрөн амьдарч буй нутагт үндэстэний районы өөртөө засахыг хэрэгжүүлэх нь хятад улсын үндсэн тогтолцооны нэг билээ. Үндэстэн болгоны өөртөө засах орон нутгийн иргэд тухайн газрынхаа нөхцөлд байдалд тулгуурлан эдийн засаг, соёл, боловсролын хөгжилд оролцох эрхтэй бөгөөд уламжлал, зан заншил, хувцас, шашин шүтлэг, хэл яриа, бичиг үсгээ чухалчилан хөгжүүлж байна. Улсаас санхүүгийн талаар дэмжих бодлого барьж, цөөн тоот үндэстний газар нутгийн үндсэн бүтээн байгуулалтанд хөрөнгө оруулж байна.

- Хятад улсад одоогийн байдлаар будда, бумба, христос, католик зэрэг шашныг 100 сая гаруй хүн шүтэж байна. 90-ээд оны сүүлээр Хятад улсад шашны номлогчид 300 мянга гаруй, шашны байгууллага 3000 гаруй байна. Шашин бүрийн хууль ёсны үйл ажиллагаа төрийн хамгаалалтанд байдаг.

Ашигласан эх сурвалж:

1. UNDP, HUMAN DEVELOPMENT REPORT 1995, New York. 1995.
2. Хэ Аркан, У Зинлянь, Carl Riskin нар, “Хятад: Хүний хөгжлийн илтгэл – Хүний хөгжил ба ядуурлыг тэтгэх, 1997” United Nations Development Programme, China.
3. Янь Цинвэй нар, БНХАУ-ын улсын хөгжлийн төлөвлөлтийн хороо, “Өнөөгийн хятадын нийгмийн хөгжил (Social Development in Today's China)”, 2000 он.
4. Chen Jinhua, “REPORT ON CHINA'S NATIONAL ECONOMIC AND SOCIAL DEVELOPMENT FOR 1996”, China Planning Press” Beijing, Published in March 1996.
5. Чэнь Яобан, “Kechixu fazhan”, Хятадын “Jihua” хэвлэлийн газар, 1996 оны 11-р сарын эхний дугаар.

Хятад хэлнээс орчуулсан: Хүмүүнлэгийн
ухааны Их сургуулийн IV курсийн оюутан
Ж.Хатанхүү